

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2024/08/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2024 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Анхтуяа Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn</p>
----------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govissumber@audit.gov.mn

ᠮᠤᠮᠤᠯᠤᠯ. ᠮᠤᠯᠤᠯ. ᠮᠤᠯᠤᠯ. № 18

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020046

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 27 зорилтын хүрээнд 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	628,675,817.74
33	АВЛАГА	457,540,200.00	628,675,817.74
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	108,558,476.74
33500	Бусад авлага	0.00	558,841.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	558,841.00
33600	Зээлийн авлага	0.00	519,558,500.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	0.00	519,558,500.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	457,540,200.00	519,558,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	628,675,817.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	628,675,817.74
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	628,675,817.74
51200	Хуримтлагдсан үр дүн	0.00	628,675,817.74
51210	Өмнөх үеийн үр дүн	386,819,390.00	457,540,200.00
51220	Тайлант үеийн үр дүн	70,720,810.00	171,135,617.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	457,540,200.00	628,675,817.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	655,547,000.00	648,510,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	655,547,000.00	648,510,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	655,547,000.00	648,510,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,940,000.00	34,213,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,940,000.00	8,656,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	652,607,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	652,607,000.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	584,826,190.00	477,374,382.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584,826,190.00	477,374,382.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,930,700.00	36,103,659.12
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,930,700.00	36,103,659.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,930,700.00	36,103,659.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	221,808,870.00	187,310,023.14

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	221,808,870.00	187,310,023.14
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,940,000.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,940,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	133,022,320.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,314,590.00	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	91,707,730.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	223,124,300.00	253,960,700.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	223,124,300.00	253,960,700.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	70,720,810.00	171,135,617.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	696,861,590.00	904,491,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,254,590.00	648,510,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,254,590.00	648,510,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,254,590.00	648,510,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,940,000.00	8,656,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	41,314,590.00	614,297,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	652,607,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	652,607,000.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	919,985,890.00	904,491,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	919,985,890.00	904,491,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,930,700.00	36,103,659.12
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,930,700.00	36,103,659.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,930,700.00	36,103,659.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	916,055,190.00	868,388,040.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	916,055,190.00	505,868,864.14
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	556,968,570.00	505,868,864.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,940,000.00	108,558,476.74
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	133,022,320.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,314,590.00	0.00

213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	91,707,730.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	223,124,300.00	253,960,700.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	223,124,300.00	253,960,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-223,124,300.00	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	223,124,300.00	0.00
14	Бусад эх үүсвэр	223,124,300.00	0.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	223,124,300.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	457,540,200.00	0.00
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	457,540,200.00	0.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	457,540,200.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	457,540,200.00
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	171,135,617.74	171,135,617.74
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	0.00	0.00	628,675,817.74	628,675,817.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	618,797,000.00	541,972,523.26	541,972,523.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	618,797,000.00	541,972,523.26	541,972,523.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,000,000.00	36,103,659.12	36,103,659.12
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,000,000.00	36,103,659.12	36,103,659.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,000,000.00	36,103,659.12	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	579,797,000.00	505,868,864.14	505,868,864.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	579,797,000.00	505,868,864.14	505,868,864.14
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	579,797,000.00	505,868,864.14	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	618,797,000.00	650,531,000.00	650,531,000.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	618,797,000.00	641,910,000.00	641,910,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500,000.00	25,557,000.00	21,057,000.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,056,000.00	2,056,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	614,297,000.00	614,297,000.00	0.00
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	8,621,000.00	8,621,000.00
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	0.00	8,621,000.00	8,621,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 158,125.0 мянган төгрөгийн орлогын 1, 223,566.5 мянган төгрөгийн зарлагын 15 гүйлгээ, 53,057.6 мянган төгрөгийн 20 шийдвэр, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбарыг /улирал бүр/ тус тус мэдээлээгүй, 12 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нийт 422,495.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.4.5, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.1.13, 2.2.3.2, 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.2.10, 3.2.11 дэх заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийг бүрэн арилгах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар нийт 3,170.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,170.0 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулсан алдаа:

1. Аж ахуйн материалын орлого, зарлагыг 2,894.5 мянга, тээвэр шатахууны орлого зарлагыг 275.5 мянга нийт 3,170.0 мянган төгрөгөөр няравын тайлангаас зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр 14.4.5, 14.4.6, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” НХМаягт БМ-2, НХМаягт БМ-3, НХМаягт БМ-9 заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй

Залруулаагүй алдаа:

Байхгүй

Аудитаар нийт 2,153.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 169.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,984.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Тээвэр шатахууны тайланд 169.1 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дэх заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

Байхгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шивээговь, Баянтал сумдад томилолтоор ажилласан албан хаагчдад байрны зардлыг тооцож нийт 1,984.0 мянган төгрөгийн томилолтын зардал илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дэх заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шивээговь, Баянтал сумдад томилолтоор ажилласан албан хаагчдад томилолтын зардлыг олгохдоо байрны зардал олгохгүй байх, төсвийг үр ашигтай арвилан хэмнэлттэй байхаар зарцуулах

2. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

31 зээлдэгчийн хугацаа хэтэрсэн зээлийн нийт 100,052.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. /Нийт 80,454.0 мянган төгрөгийн 19 зээлдэгчид мэдэгдэх хуудас хүргүүлээгүй, нотлох баримтаар баталгаажаагүй/

Өгсөн зөвлөмж:

Хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жолоочийн тооцооны хуудсанд тухайн байгууллагын автомашин нь ямар албан тушаалтны ямар хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг бичээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар" НХМаягт ТМ-4 заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жолоочийн тооцооны хуудсанд ямар албан тушаалтны ямар хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг тодорхой бичих, хэдэн км зарцуулснаа хянаад гарын үсэг зурах, нягтлан бодогч тооцоог хийж шатахууны хэтрэлт хэмнэлтийг гаргах

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	3.2			1	3.2	1	3.2				
Дүн	1	3.2			1	3.2	1	3.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	4	2.2	1	0.2			3	2.0				
Дүн	4	2.2	1	0.2			3	2.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	422.5					1	422.5				
Дүн	1	422.5					1	422.5				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан												
Дүн												
Нийт дүн	1	422.5					1	422.5				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			